



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/123

Арвайхээр сум

Газар эзэмших эрх нэгтгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3, 43 дугаар зүйлийн 43.1, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/187 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 8.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын инженерийн шугам сүлжээ бүхий газарт байрлах 2 нэгж талбарыг эзэмшигчийн хүсэлтийн дагуу хавсралтад зааснаар газар эзэмших эрхийг нэгтгэсүгэй.

2. Дээрх газар эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн “Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх тухай” А/611 дүгээр захирамжийн хавсралтын А.Төмөрхуягтай холбогдох хэсэг, 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн “Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгах тухай” А/39 дүгээр захирамжийн хавсралтын А.Төмөрхуягтай холбогдох хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцугай.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

9224 11 0262

Аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 7105 дугаар захирамжийн хавсралт



ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХ НЭГТГЭЖ БУЙ НЭГЖ ТАЛБАРЫН МЭДЭЭЛЭЛ

Д/Д	Газар эзэмшигчийн овог, нэр (Хуулийн этгээдийн нэр)	Эзэмшигчийн регистрийн дугаар	Газрын зориулалт	Газрын хэмжээ (м ²)	Нэгж талбарын дугаар	Газар эзэмших эрх шилжүүлэн авагчийн овог, нэр (Хуулийн этгээдийн нэр)	Эрх шилжүүлэн эзэмшигчийн регистрийн дугаар	Газрын зориулалт	Газрын хэмжээ (м ²)	Газрын байршлын нэр, хаяг	Эзэмших хугацаа
1	А.Төмөрхуяг	ЙЭ50071115	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, цогцолбор төв	466	6216034249	А.Төмөрхуяг	ЙЭ50071115	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, цогцолбор төв	803	13 дугаар баг, Б.Ренчинпэл жээ-1 гудамж, 109 тоот	15 жил
2	А.Төмөрхуяг	ЙЭ50071115	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, цогцолбор төв	337	6216034280						